



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 1/197

Арвайхээр

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан

авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: -Б.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Мөнхнасан - Аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал

Т.Нарангарав Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ш.Авиurmэд Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100434